

БАЯНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 15

Бүрд

Сумын ИТХ-ын хуралдаанаар засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, 2025 оны сумын хөгжлийн төлөвлөгөөг хэлэлцүүлэн батлуулаад 1 жил болж байна. Мөрийн хөтөлбөр, хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүднээс Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны календарчилсан төлөвлөгөөг боловсруулан баталж ажиллаж байна

2025 оны хөгжлийн төлөвлөгөө нь 11 зорилт бүхий 47 хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн батлуулж хэрэгжилтийг ханган ажиллалаа. Хөгжлийн төлөвлөгөөний биелэлт 92 хувьтай байна.

Сумын ИТХ-ын хуралдаанаар сумын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний тайланг хэлэлцүүллээ

**Боловсрол хөгжлийн тулгуур зорилтын хүрээнд 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс сайн багш таны дэргэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.** 2024-2025 оны хичээлийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээр 74,5 хувьтай шалгагдлаа.

Дотуур байрны барилга 95 хувийн гүйцэтгэлтэй байна.

Үдийн хоол үйлдвэрлэл тоног төхөөрөмжөөр хангагдсан. Дотуур байрны гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчлэхээр холбогдох судалгааг гарган дээд шатны байгууллагад уламжлаад байна.

**Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх дасгал хөдөлгөөн спортоор хичээллэгсдийн тоог 5 хувиар нэмэгдүүлнэ гэсэн зорилтын хүрээнд 3 арга хэмжээг төлөвлөсөн.**

Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхэд анхаарч “Дасгал хөдөлгөөн-эрүүл мэнд” аяныг засаг даргын захирамжаар зарлан явуулж төрийн албан хаагчид, иргэд нарны алхалт, дасгал хөдөлгөөнд идэвхтэй хамрагдлаа.

Баяраа багштай жүдо бөхийн дугуйлангийн сурагчдыг уралдаан тэмцээнд оролцоход нь дэмжлэг үзүүлж засаг даргын нөөцөөс 300,000 мянган төгрөг, Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль хүртсэн Д.Өлзийбатад 500,000 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал тус тус олголоо. Ахмад настнуудыг Засаг дарга хүлээн авч тэдний чөлөөт цагийг зөв боловсрон өнгөрүүлэхэд спорт заалны цагийг Бямба гаригт, Даваа гаригт соёлын төвд тус тус олгож байна.

Хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх цэцэрлэгт хүрээлэнг 7-р сарын 20-ны дотор хүлээлгэн өгөхийг гүйцэтгэгч компанид албан тоотоор болон

компанийн захиралтай биечлэн уулзаж үүрэг болгож ажилласны дүнд ажлаа бүрэн хийж дуусгасан

Иргэдийн бие бялдрын өсөлт хөгжилтөнд анхаарч чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмжийг гэрээ байгуулан гүйцэтгүүлж фитнес клуб байгуулагдан үйл ажиллагаа нь жигдрээд байна

**Иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүрээмжийг нэмэгдүүлнэ гэсэн зорилтын хүрээнд 2 арга хэмжээг төлөвлөсөн.**

Сумын хэмжээнд эрт илрүүлгийн үзлэгт хамрагдалт 67 хувьтай байна

Эрүүл шүд арга хэмжээ хөтөлбөрийн хүрээнд "Хант групп" ХХК, ЭМГ, ЭМТ гурвалсан гэрээ байгуулж амны хөндий болон шүдний урьдчилан сэргийлэх үзлэгт 317 хүүхэд хамрагдсан.Төрийн албан хаагчид болон эцэг эх асран хамгаалагчдад амны хөндийн эрүүл ахуйн сургалт зөвлөгөөг 2 удаа зохион байгууллаа.6 настай хүүхдийн шүдний товлोलт үзлэгт 33 хүүхэд хамрагдахаас бүрэн 100 хувь хамрагдлаа.

Бага ангийн хичээлийн байранд 10 угаалтуур бүхий 2 шүд угаах буланг байрлуулсан.Бага ангийн сурагчид үдийн хоолны дараа хуваарийн дагуу шүдээ угааж хэвшсэн.

Бусад зорилт арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

#### **Удирдлага зохион байгуулалтын талаар:**

Сумын Засаг даргын Тамгын газраас "Малчид төлчдийн зөвлөгөөн зохион байгууллаа.Энэ зөвлөгөөнд аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхжаргалаар ахлуулсан ажлын хэсэг болон сумын Засаг дарга Д.Батболд, ИТХ-ын дарга Ч.Эрдэнэбилэг, Засаг даргын Тамгын газрын мал эмнэлэг, хөдөө аж ахуйн тасаг, нийт ажилтнууд, аймгийн хэлтэс, агентлагийн мэргэжилтнүүд оролцож шинээр гарсан хууль тогтоомж аймаг, сум орон нутгаас хийж хэрэгжүүлж байгаа ажлын мэдээлэл танилцуулгыг тус тус хийлээ.

Улаанбаатар хотын Цэц баян ХХК-ны захирал Ж.Мөнхсайхан, Хүмүүнлэгийн их сургуулийн багш доктор Л.Ариунаа, МУ-ын харцага Н.Золбоот, Пүрэвгарьд, начин Ж.Чулуунбат тэргүүтэй бөхчүүд урилгаар оролцож малчид төлчдөд бизнес санхүү, хуримтлал үүсгэх талаар сургалтыг доктор багш Л.Ариунаа, Ж.Мөнхсайхан нар хийсэн. Малчид төлчдийн дунд волейболын болон дардасны тэмцээн, улсын цолтой болон цолгүй, бөхийн барилдааныг зохион байгууллаа.

Цэргийн тоо бүртгэлийн ажлыг Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг зохион байгуулж сумын хэмжээнд 1, 2 зэргийн цэргийн үүрэгтнүүд 93 хувьтай бүртгэлд хамрагдлаа.2025 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагын ажлыг зохион байгуулсан .2025-2027 онд цэргийн албыг дүйцүүлэх хэлбэрээр 3 цэрэг хаахаар цэрэг татлагын товчооны шийдвэр гарсан. Мөн "Цагаан сар" үзэсгэлэн худалдаа"-г зохион байгууллаа.Гар

урлалын төрөлд 4-р багийн өндөр настан С.Должинсүрэн шилдэг үйлдвэрлэгчээр, шилдэг цагаан идээ үйлдвэрлэгчээр "Таван буур" хоршоо, 2-р багийн малчин М.Гандолгор нар шалгарч шагнал авсан.Урилгаар оролцсон бөхчүүд болон компанийн захирлууд баг бүрээс 4 малчинг шалгаруулж тавгийн боов, гарын бэлгээр урамшууллаа.

Засаг даргын Тамгын газар, Үйлдвэрчний эвлэл, соёлын төвөөс санаачлан зохион байгуулан явуулсан баг байгууллага сурталчлах урлагийн наадамд баг байгууллагууд амжилттай оролцож 1 дүгээр байрыг Засаг даргын Тамгын газар, Бүрд 4-р баг, 2 дугаар байрыг Цэцэрлэг, 1-р баг, 3 дугаар байрыг ЕБС, 3-р баг, тусгай байрыг Эрүүл мэндийн төв, 2-р баг тус тус эзэлж өргөмжлөл, мөнгөн шагнал гардан авсан.Удирдамжийн дагуу сайн үйлсийн аянг Засаг даргын Тамгын газар, Бүрд 4-р баг өрнүүлж 2,800,000 төгрөг цуглаж 43 өрхөд 300 кг нүүрс, 120 өрхөд 1 боодол өвс, улаан буудайг олголоо

Баянхонгор аймгийн ГБХЗХГ-ын дарга Н.Мэндбаяр даргатай ажлын хэсэг тус сумд ажиллаж сумын хэмжээнд гэр бүл, хүүхдийн хүчирхийлэлийн эсрэг ажил үйлчилгээ явуулах тандалт судалгаа хийх талаар зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж сум бүр хүүхэд гэр бүлийн ажилтантай болж байгаатай холбогдуулан П.Алтан-Одыг сумын гэр бүл хүүхэд хамгааллын ажилтнаар томилж засаг даргатай гурвалсан гэрээг байгууллаа.

Аймгийн Мал эмнэлгийн газрын дарга Л.Оюун-Эрдэнэ тус сумд ажиллаж малын гоц халдварт болон халдварт бус өвчлөлийн талаар ард иргэдэд мэдээ мэдээлэл өгч ажиллахыг сум, багийн удирдлагуудад үүрэг болгож аймгийн мал эмнэлгийн газрын ажлын тайлан танилцуулга хийлээ.

Билгийн тооллын сар шинийн нэгдсэн золголтыг сумын соёлын төвд зохион байгуулж сумын аварга малчид болон байгууллагын аварга ажилтнуудыг алдаршуулж шагнаж урамшуулах ёслолын ажиллагааг явуулсан.80-с дээш настай 5 ахмад настанд сумын Засаг дарга хүндэтгэл үзүүлэн золгож гарын бэлэг өглөө.Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот дахь нутгийн зөвлөлтэй хамтран сар шинийн нэгдсэн золголтыг зохион байгуулсан.

Баянхонгор аймаг дахь нутгийн зөвлөлтэй хамтран нутгийн зөвлөлийн уулзалт, Баянбулаг сумын нэрэмжит үндэсний бөхийн барилдааныг амжилттай зохион байгууллаа.

### **Хоёр.Эдийн засаг, төсөв санхүүгийн бодлогын хүрээнд**

Санхүүгийн алба төсөвт байгууллагуудын батлагдсан төсвийг зүйл заалтын дагуу санхүүжилтийн сарын хуваарийн дагуу гүйлгээг хийж байгууллагуудын цалин бусад гүйлгээг хугацаанд нь тавьж олголоо.11 сарын байдлаар 2 сан болон төсвийн байгууллагууд 1375 ширхэг буюу 3,300,139,068 төгрөгийн гүйлгээг төрийн сангийн удирдлагын цахим системээр амжилттай хянагдаж гүйлгээ хийгдсэн..Сумд төвлөрөх орлогын төлөвлөгөө 535.525,0 төгрөг гүйцэтгэл 708,216,3 төгрөг буюу төлөвлөгөөний биелэлт 132,2 хувьтай байна.Төрийн өмчийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу үнэлгээний хороо байгуулан ЕБС үдийн цай,

хоолны бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгууллаа. Төсөвт байгууллагуудын 2024 оны санхүүгийн баримтыг аудитаар шалгуулж зөрчилгүй дүгнэлт авсан. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг ИТХ-ын хуралдаанаар батлуулан хийгдэх ажил арга хэмжээнээс 9 гэрээгээр 2 ажлыг хуулийн дагуу сонгон шалгаруулалтыг хугацаанд нь зарлан явуулж гүйцэтгэгч компаниудтай гэрээ байгуулан ажлууд хийгдсэн.

**Гурав. Хууль эрх зүйн бодлогын хүрээнд:**

Засаг даргын Тамгын газраас эрх зүйн сургалт сурталчилгааны төлөвлөгөөний дагуу "Нийгмийн халамжийн тухай хууль болон эхийн алдар одон олгох журмын талаар төсвийн байгууллагуудын ажилтнууд болон иргэдэд сургалт хийлээ. Нийт 205 хүн хамрагдлаа.

Багуудын ИНХ-ыг хуралдуулж хууль тогтоомж, цаг үеийн ажлаар Засаг дарга, Тамгын газрын мэргэжилтнүүд сургалт мэдээлэл хийж малчдын саналыг сонслоо. Үүнд нийтдээ 445 хүн оролцсон

Хангайн бүсийн ИТХ-ын төлөөлөгчдийн туршлага солилцох уулзалт, соёл спортын тэмцээн тус сумд зохион байгуулагдлаа. Энэ арга хэмжээнд сумын Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга нар оролцож бусад сумдын хурлын байгууллагын үйл ажиллагааны танилцуулга болон Аймгийн ИТХ-ын ажлын албаны хууль эрх зүйн боловсролын чиглэлээр явуулсан хуулийн сургалтад хамрагдсан.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга Д.Сарангараваар ахлуулсан ажлын хэсэг болон хууль сахиулах байгууллагуудын сургалт нөлөөллийн арга хэмжээг хамтран зохион байгууллаа. Энэ арга хэмжээг төрийн албан хаагчид, иргэд, сурагчид гэсэн ангиллаар хууль эрх зүйн сургалтуудыг явуулсан нь иргэдийн хууль эрх зүйн мэдлэг нэмэгдсэн арга хэмжээ болсон.

"Суралцагч сум" төсөлт арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг засаг даргын захирамжаар байгуулан ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Төрийн албаны зөвлөлөөс тус сумд ажиллаж төрийн захиргааны албан хаагчийн болон байгууллагын удирдах албан тушаалтны томилгооны зөрчил, Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийн байдлыг газар дээр ирж үзэж шалган заавар зөвлөгөө өгч төрийн албан хаагчдаас судалгаа авч ажиллалаа.

"Суралцагч сум" төсөлт арга хэмжээний нээлтэд аймгийн насан туршийн суралцахуйн төвийн захирал Д.Амгалан, мэргэжилтнүүдийн хамт оролцож сургалт сурталчилгаа цаашид энэ төсөлт арга хэмжээг хэрэгжүүлэх талаар зөвлөмж заавар өгч ажиллалаа. Энэ арга хэмжээнд 219 хүн оролцож хууль эрх зүйн болон амьдрах ухааны мэдлэг мэдээлэлээ нэмэгдүүлсэн.

Энэ төсөлт арга хэмжээний төлөвлөгөөний дагуу заавал мэдвэл зохих 4 хуулийн цахим уралдаанд сумын төрийн байгууллагуудаас 4 баг амжилттай оролцлоо.

Засаг даргын Тамгын газраас "Архины зөв зохистой хэрэглээ" сэдвээр Засаг дарга Д.Батболд, халамжийн мэргэжилтэн Б.Отгонцэцэг нар сургалт зохион байгууллаа. Үүнд нийтдээ 113 иргэд оролцлоо. Төрийн байгууллага бүр хуулийн сургалт зохион байгуулсан. Төрийн албан хаагчид, иргэд идэвхтэй хамрагдсан. 4 байгууллагын хууль эрх зүйн сургалтад давхардсан тоогоор 375 хүн хамрагдсан байна.

Засаг даргын Тамгын газраас "Дэвжээ" тэмцээн 2 удаа зохион байгууллаа. АХА тэмцээн 1 удаа явууллаа.

Сумын эмэгтэйчүүдийн 9-р чуулганыг Хангал 3 дугаар багийн эмэгтэйчүүдийн зөвлөл, Засаг даргын Тамгын газар, соёлын төв хамтран амжилттай зохион байгуулж явууллаа. Үүнд нийтдээ 203 эмэгтэй оролцсон байна. Эмэгтэйчүүдийн зөвлөлийн даргыг шинээр сонгох асуудлыг хэлэлцэж нийт зөвлөгөөнд оролцогчдын олонхийн саналаар цэцэрлэгийн эрхлэгч Л.Энхцэцэг сумын эмэгтэйчүүдийн зөвлөлийн даргаар сонгогдлоо. Эмэгтэйчүүдийн өмнө тулгамдаж байгаа асуудал болон эмэгтэйчүүдийн зөвлөлийн ажлын болон санхүүгийн тайланг хэлэлцүүлж эмэгтэйчүүдийн дунд спорт урлагийн тэмцээнүүдийг амжилттай зохион байгууллаа.

Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн гишүүн Д.Ундраа, аймгийн ГБХЗХГ-ын дарга Мэндбаяр нараар ахлуулсан аймгийн хүүхдийн төлөө зөвлөлөөс шинээр батлагдан гарсан хууль тогтоомжоор төрийн албан хаагчид, иргэдэд сургалт зохион байгууллаа. Энэ сургалтад 119 хүн оролцсон байна.

Сумын хүүхдийн чуулганыг зохион байгуулж хүүхдийн санал бодлыг сонсож тэднээс гаргасан санал хүсэлтийг шийдвэрлэн ажиллаж байна

Аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн дарга Д.Сарангарав, хууль эрх зүйн хэлтсийн бүх мэргэжилтэн сумын төрийн байгууллагуудын гаргаж буй тушаал шийдвэрүүдийг үзэж зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж зөвлөмж өгч ажиллалаа.

"Хуулиа дээдлээ" аяны хүрээнд төрийн албан хаагчдын дунд цахимаар зохион байгуулсан 1-р шатны уралдаанд төрийн байгууллагуудаас 4 баг оролцож Засаг даргын Тамгын газрын Сүлд баг 1-р байр, 2-р байрыг цэцэрлэг, 3-р байрыг ерөнхий боловсролын сургууль, тусгай байрыг Соёлын төв эзэлсэн. Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын ахлах мэргэжилтэн Наранбаатараар ахлуулсан ажлын хэсэг тус сумд ажиллаж байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтийг газар дээр нь үзэж зөвлөгөө заавар өглөө.

Иргэний 8 төрлийн бүртгэлийн төрсний бүртгэлд 6, иргэний цахим үнэмлэх олголтын бүртгэлд 49, шилжин суурьших хөдөлгөөн-8, нас барсаны бүртгэл 9, үрчлэлт 1, гэрлэсний бүртгэл 5 хийж мэдээллийн санд орууллаа.

Нотиаротын үйлчилгээ гэрээ итгэмжлэл 85, бичиг баримтын хуулбарын үнэн зөвийг баталсан 428 хүнд үзүүлсэн байна.

Алдарт эхийн 1, 2 дугаар зэргийн одонд шинэ журмын дагуу 15 ээжийн материалыг бүрдүүлэн аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргаа удирдлагын хэлтэст хугацаанд нь хүргүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Алдарт эхийн 1 зэргийн одонгоор 2 ээж, Алдарт эх 2-р зэргийн одонгоор 13 ээжийг шагнах ёслолын ажиллагааг ЗДТГ-с эх үрсийн баяраар зохион байгуулж гардуулж одон авсан ээжүүдэд гэр бүл, ах дүүс, найз нөхөд нь хүндэтгэл үзүүлсэн сайхан арга хэмжээг явууллаа.

Билгийн тооллын хаврын тэргүүн сарын баярын өдрүүдэд нийтийн эргүүл ажиллуулах засаг даргын захирамж гарган хуваарийн дагуу эргүүлийн үүрэг 4 цагийн зайтай гүйцэтгүүлж мэргэжлийн удирдлагаар цагдаагийн хэсгээс ханган ажилласан.

2025 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар Засаг даргын захирамж 83, Засаг даргын Тамгын газрын даргын тушаал 34, Тамгын газарт дээд байгууллагаас ирсэн бичиг 125, үүнээс хариутай 26 бичгээс одоогийн байдлаар 20 бичгийн хариуг явуулж 3 бичгийн хариу өгөх хугацаа болоогүй, дээд байгууллагад явуулсан бичиг 69 бүртгэгдсэн бичиг хэргийн эргэлтийн мэдээтэй байна.

E-Mongolia.mn болон үйлчилгээний оператороор дамжуулан нийт 300 лавлагаа гаргасан. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган [www.shilen.gov.mn](http://www.shilen.gov.mn) бүртгэл мэдээллийн цахим санд нээлттэй байршуулах 98 төрлийн тайлан мэдээг байршуулан дээд шатны байгууллагаар үнэллүүлээ

#### **Нийгмийн хамгааллын бодлогын чиглэлээр:**

Өрхийн мэдээллийн нэгдсэн санг ашиглах өрхийн орлогыг тодорхойлох санал асуулга үнэлгээний ажлыг зохион байгуулж 4 багийн сонгогдсон өрхүүдээс халамжийн мэргэжилтэн, багийн засаг дарга хамтран санал асуулга авч цахим программд хугацаанд 75 өрхийн мэдээллийг нь шивж нэгтгэсэн. Нийгмийн даатгалын сангаас болон халамжийн сангаас олгох тэтгэвэр тэтгэмжүүдийг цаг хугацаанд нь тавьж олгоод байна. Нийгмийн халамжийн болон нийгмийн даатгалын тухай хуулиар 4 багийн ИНХ-д оролцож мэдээлэл хийсэн

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 26 иргэн хамрагдаж 1,142,154 төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмжид 76 иргэн 250,010,809 төгрөг, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид 17 иргэн хамрагдаж 41,420,373 төгрөг, ахмад настны хөнгөлөлт тусламжид 6 ахмад настанд 5,772,750,000 төгрөг, насны хишгийн тэтгэмжид 102 ахмад настанд 15,660,000 төгрөг, эхийн одонгийн тэтгэмжид 177 ээж 46,800,000, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт тусламжид 18 иргэнд 2,710,000 төгрөг, 0-3 насны хүүхэд асарсны тэтгэмжид 56 иргэнд 27,975,738, өрх толгойлсон эх эцэгт олгох тэтгэмжид 3 иргэн хамрагдаж 6,331,648, жирэмсэн эхийн тэтгэмжид 14 эхэд 4,369,885 төгрөг, 0-18 насны хүүхдүүдийн мөнгөн тэтгэмжийг холбогдох хууль тогтоомжийн дагуу 623 хүүхдэд 626,900,000 төгрөг, Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг 19 өрхийн 72 хүнд 9,656,000 төгрөг тус тус

олгоод байна. Нийтдээ 11 сарын байдлаар 10544 хүнд 1247.539.654 төгрөгний үйлчилгээг нийгмийн халамжийн сангаас үзүүлсэн байна.

**Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд:** Сумын Засаг дарга Д.Батболдоор ахлуулсан ажлын хэсэг Хүрээмарал, Бууцагаан сумдад отроор яваа малчин өрхүүдэд төрийн болон эрүүл мэндийн, мал эмнэлгийн үйлчилгээг үзүүлж ажилласан. Үүнд 13 өрхийн 35 хүн, 8600 мал отроор явж өвөлжсөн.

Малчид төлчдийн зөвлөгөөнийг амжилттай зохион байгууллаа. Энэ зөвлөгөөнд аймгийн Хөдөө аж ахуйн газрын үйлдвэрлэл үйлчилгээний хэлтсийн дарга Мөнхтогтох,

Мал эмнэлгийн газрын улсын хяналтын байцаагч Л.Ганбаяр нар оролцож аймгийн хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбарт баримталж байгаа бодлого, цаашид хийж хэрэгжүүлэх ажлын мэдээлэл танилцуулга хийлээ. Мал эмнэлгийн тасгийн дарга Б.Энхболд мэдээлэл сургалт явууллаа. Малчдын зөвлөгөөн дээр тэргүүний малчдыг аймгийн тэргүүний ажилтан, Засаг даргын жуух бичгээр шагнаж урамшуулсан. Салбар салбарын төлөөлөл мэдээлэл, танилцуулга, сургалт хийж энэ зөвлөгөөнөөс малчид иргэд сонсож мэдсэн зүйл ихтэй шинээр санаачлах хүсэл тэмүүлэлтэй үр өгөөжтэй зөвлөгөөн болсон нь онцлог байлаа. Нийтдээ 220 малчин, хот аймгийн 40 гаруй зочид төлөөлөгчид оролцсон их цар хүрээ өндөртэй зөвлөгөөн боллоо. Хөдөө аж ахуйн тасгаас "Цагаан сар үзэсгэлэн худалдаа" зохион байгуулж амжилттай оролцож тэргүүлсэн малчид, иргэдийг шагнаж урамшуулсан. Аймгийн аварга малчнаар Ар жаргалант 2 дугаар багийн малчин Р.Бат-Эрдэнийн гэр бүл, Хангал 3-р багийн малчин Р.Жамъянсүрэнгийн гэр бүл шалгарч аваргын шагналыг аймгийн ЗДТГ-ын дарга Д.Энхжаргалаар ахлуулсан ажлын хэсэг сумын удирдлагууд гардууллаа. Сумын аварга малчнаар 7 гэр бүл шалгарч билгийн тооллын сар шинийн нэгдсэн золголтын арга хэмжээн дээр шагналыг гардуулж алдаршуулсан. Сумын хэмжээнд эхний хагас жилийн байдлаар 2 хоршоо шинээр байгуулагдаж холбогдох төсөл материалаа бүрдүүлэн ХААН банкинд хүргүүлээд байна.

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 15000 мал хамрагдаад байна.

Малын хагас жилийн тооллого явагдаж түүвэр судалгаагаар сонгогдсон 81 өрхүүдийн малыг засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг багуудад ажиллаж тоолон дүнг нэгтгэн цахим санд хугацаанд нь орууллаа.

Аймгийн ХАА-н газраас хувиарласан 4 тонн бактержуулсан будааг 2000 га талбайд цацах ажлыг ажлын хэсэг томилон 4 багт зохион байгуулж ажиллалаа.

Шинээр 2 хоршоо байгуулагдан холбогдох материалаа бүрдүүлэн ХААН банкинд зээлийн хүсэлтээ хүргүүлээд хүлээгдэж байна.

Шинэ хөдөө туршлага солилцох сургалтад Хятад улсын Шилийн гол руу Ихэр жаргалантын бүүвэй, Халзан хангайн нөмөр хоршооны төлөөлөл 2 иргэнийг оролцуулж туршлага судлууллаа.

### **Байгаль орчин газрын харилцааны чиглэлээр:**

Цагаан сараа хоггүй угтах ажлын хүрээнд нийтийн эзэмшлийн гудамж талбайн хогийг ард иргэдийн дэмжлэгтэйгээр цэвэрлэж хог хаягдлын карьерт асгасан.

Засаг даргын Тамгын газрын эрчүүд хамтран эзэнгүй нохой устгах ажлыг 2 удаа явууллаа. Нийт 32 нохой устгаж иргэдэд нохойгоо өглөө 6-23 цаг хооронд уяж хэвшихийг анхааруулж хууль тогтоомжийг танилцуулж ажилласан бөгөөд ард иргэд болон бага насны хүүхдийн аюулгүй байдал, хөрсний бохирдлоос сэргийлэх зэрэг олон ач холбогдолтой ажил байлаа. Бүрд булгийн эрэг дагуух мөс зузаарч мал услахад хүндрэлтэй болсон хэсгүүдийн мөсийг багасгах ажлыг ЗДТГ-ын эрчүүд хамтран хийлээ.

Ус тээврийн машины жолоочийг гэрээтээр ажиллуулж Хавцлын амны худгаас ус тээвэрлэн сумын төвийн айл өрхийг ундны цэвэр усаар хангах ажлыг хийж эхлээд байна. Зэрлэг ан амьтдыг идэш тэжээлийн дутагдлаас сэргийлэх зорилгоор биотехникийн арга хэмжээг 3 удаа Засаг даргын Тамгын газрын ажилтнуудыг татан оролцуулж Сангийн далайн 1-р багийн Баянцагаан, Өндөр өлзийт, Хангал 3-р багийн Хайрханы нуруу, Ар жаргалант 2-р багт Хөх булаг, оцон хүрэн гэх газруудад 320 орчим янгир ямаанд өвс хужир тавьж 6 цэг сонгон хээрийн хяналтын камерыг суурилууллаа. Энэ ажилд 3,500,000 төгрөг зарцуулсан байна.

Ерөнхий боловсролын сургуулийн эко бүлгийн сурагч хүүхдүүд, байгаль орчны мэргэжилтэн, хамгаалагч нарт санал хүсэлт ирүүлсний дагуу ЗДТГ-аас хог ялган ангилах, түр хадгалах цэгийг хийж гүйцэтгэлээ. Сар бүр айл өрхийн хогийг хуваарийн дагуу тохижилт үйлчилгээний жолооч, ачигч нар хогийн төвлөрсөн цэгт хүргэж хэвшсэн. Нийтийн эзэмшлийн хог хаягдлыг цэвэрлэх ажлыг 3 удаа зохион байгуулсан. Хогийн төвлөрсөн цэгийн хогийг шууж карьерт хийх ажлыг хийлээ. Хогийн цэгт 2 камер суурилууллаа.

Дэлхийн усны өдөр байгаль хамгаалах өдрүүдийн хүрээнд сурагчдын дунд "АХА" тэмцээн, гар зургийн уралдаан, шүлэг, эссэ бичлэгийн уралдаан зохион байгуулж тэргүүлсэн сурагчдад 456,000 төгрөгийн шагнал урамшил олголоо.

"Тэр бум мод" үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх мод тарих үндэсний өдрийн хүрээнд 500 мод худалдан авч айл өрхүүдэд олгож төвлөрсөн хамгаалалтын ойн зурвас бүхий талбайд 166 ш модыг төрийн байгууллагуудын албан хаагчид тарьлаа.

Бүрд 4-р багийн нарийн гудамжнуудад зам тавих ажлыг ЗДТГ-ын албан хаагчид, соёлын төвийн албан хаагчид хамтран хийлээ.

Сумын төвийн 4 дүгээр багийн гэрэлтүүлгийн байдалд үзлэг явуулж 8 байршилд 25 гэрлийг шинэчлэн сольж тавьсан.

Сумын угтах хаалгыг нарны эрчим хүчээр ажиллах гэрэлтүүлэгтэй болгох ажлыг хийлээ.

Ар жаргалант 2-р багийн иргэд Нарангийн булаг, Хойд сайхнаас Даагын булаг хүртэл хог хаягдлаа цэвэрлэж 6 машин хог хаягдлыг тээвэрлэж нэгдсэн хогийн цэгт хүргэж ажиллалаа.

Соёлын зориулалтаар идлэг шонхор барих БОЯ-ны зөвшөөрөлтэй Араб улсын ангийн отог 2 байрлаж гэрээ байгуулан байнга хяналт шалгалт хийж ажиллан сумын төсөвт ангийн орлогыг төвлөрүүлсэн. Мөн БОЯ-ны зөвшөөрөлтэй тэх агнах 1 отог байрлаж 5 тэх агнан сумын төсөвт ангийн орлого 291.000.000 сая төгрөг орууллаа.

Бусад ажлын талаар:

Эх үрсийн баяраар "Хүүхэд бидний гэрэлт ирээдүй" арга хэмжээг хүүхэд багачуудын дунд зохион байгууллаа. Энэ арга хэмжээнд 5 төрлийн тэмцээнийг сумын хүүхдийн зөвлөл амжилттай зохион байгуулж явууллаа. Үүнд нийт 209 хүүхэд оролцсон.

Эх үрсийн баяраар байгууллага бүрийн эцэг эхийн зөвлөл хүүхдүүдээ хүлээн авч хүндэтгэл үзүүлэн бэлэг гардууллаа.

Улаанбаатар хотын нутгийн зөвлөл, сум дахь Амгалан сайн хийд, Засаг даргын Тамгын газар хамтран нутгийн хилээр "Гаанжуур, Даанжуур хөлгөн судрыг тойруулж Баянбулаг хайрхан, Өндөр өлзийт хайрхануудыг тахих овоо тахилгын наадмыг зохион байгууллаа.

Малчид иргэдийн хүсэлтээр өвөлжөө, хаваржааны бууцыг түрэх ажлыг трактороор хийж гүйцэтэж байна.

Тамгын газрын албан хаагчид үндсэн ажлаас гадна гамшиг ослын дуудлага, хүн, мал эрэх, авран хайх, өвс буулгах, хураах, хөв цөөрөм, нохой устгал, мод тарих, зэрэг нийтийг хамарсан ажилд байнга ажиллаж дээр үеийн нэгдлийн ажлыг давхар гүйцэтгэн ажиллаж байна.

Хууль тогтоомж, аймгийн ИТХ, засаг даргын захирамж албан даалгавар, аймгийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээ болон бодлогын бичиг баримтуудын эхний хагас жилийн тайлан хяналт шинжилгээ үнэлгээний цахим программд хугацаанд нь нэгтгэн тайлагнаж баталгаажуулсан. Мөн 3-р улирлын тайланг цахим программд хугацаанд нь нэгтгэн баталгаажуулсан. Жилийн эцсийн тайланг нэгтгэн баталгаажуулах ажил хугацаандаа явагдаж байна.

Эхний хагас жилийн бодлогын бичиг баримтын хяналт шинжилгээ үнэлгээгээр 20 сумаас 7-р байрт явж байна. Жилийн эцсийн бодлогын бичиг баримтуудыг хяналт шинжилгээ үнэлгээний цахим программд хугацаанд нь тайлагнах ажил хийгдэж байна. Засаг даргын Тамгын газраас эхний хагас жилд хийсэн ажлын видео танилцуулгыг ИТХ-ын төлөөлөгчид болон багуудын ИНХ дээр малчид иргэдэд танилцууллаа.

Аймгийн Засаг даргын удирдлагын багт 2025 оны 11 дүгээр сарын 19-нд Засаг даргын 2025 онд хийсэн ажлын тайлан аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилт, тулгамдсан асуудлыг танилцуулж тайлангаа тавьлаа.

Улсын арслан Э.Батмагнайд хүндэтгэл үзүүлэх наадамд Дуурсахын хөндийд 1 гэр барьж Улаанбаатар, бусад аймаг хотоос ирсэн хүндэт зочдыг хүлээн авч хүндэтгэл үзүүлж идэвхтэй оролцсон.

Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу тамгын газрын ажилтнуудыг эх орны үзэсгэлэнт байгальтай танилцуулах Баян-Өлгий Алтай таван богдын аялал зохион байгуулан оролцлоо. Монгол орны уул усны ноён оргил байгалийн сайхныг үзсэн ажилтнуудын сэтгэл ханамж өндөр байлаа.

Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу томилогдсон архив албан хэрэг хөтлөлтийн дэд ажлын хэсгийн шалгалт тус сумд 9 дүгээр сарын 22-23-ны өдрүүдэд явагдаж нийт төрийн 6 байгууллага хамрагдлаа. Энэ шалгалтад 6 байгууллага 62,5-70 хувьтай шалгагдсан дүнтэй байна.

Ахмад настны өдрийг тэмдэглэн өнгөрүүлж тэдний дунд тэмцээн уралдаан зохион байгуулж ахмад настангуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн.

Хангайн бүсийн 10 сумдын ИТХ, ЗДТГ-ын албан хаагчдын урлаг спортын бага наадамд оролцож дэд байр эзлэн өргөмжлөл 800,000 мянган төгрөгөөр шагнагдлаа. Шинэжинст сумд зохион байгуулагдсан 20 сумын ИТХ, ЗДТГ-ын албан хаагчдын ур чадвар, урлаг спортын наадамд 21 албан хаагчийг оролцууллаа.

Улаанбаатар хотын нутгийн зөвлөлтэй хамтран “Эвсэг Баянбулагчууд” уулзалт хэлэлцүүлэг, спортын уралдаан тэмцээнүүдийг Улаанбаатар хотод зохион байгууллаа. Энэ нь нутаг орны хөгжлийн гарцыг тодорхойлох томоохон арга хэмжээ болсон.

Хуулиа дээдлэе аян хүрээнд зохион байгуулагдсан 2 дугаар шатны “Дэвжээ” тэмцээнд Засаг даргын Тамгын газрын “Сүлд” баг Баянхонгор аймагт амжилттай оролцсон.

Жилийн эцсийн мал тооллогыг Засаг даргын А/107 тоот захирамжаар томилогдсон ажлын хэсэг 3 багт зохион байгуулан явууллаа. Хяналтын тооны ажлын хэсэг ажилласан ямар нэгэн зөрчил гараагүй.

ТАЙЛАН БИЧСЭН:  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Д.ЦЭНД-АЮУШ

